



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 21 өдөр


Дугаар A/93

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.



080356



ШИНЖИЛГЭЭНИЙ СОРЬЦ ЗӨӨВӨРЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүлээгдэл, чирэгдлийг бууруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд оршино.
2. Энэ журмаар шинжилгээний сорьцыг эрүүл мэндийн байгууллага хооронд зөөвөрлөхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулна.
3. Энэхүү журмыг эрүүл мэндийн бүх байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй мөрдөнө.
4. Шинжилгээний сорьцыг цуглуулах, тээвэрлэгчид хүлээлгэн өгөх, шинжлэх, шинжилгээний хариуг илгээх бүх үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэнэ.
5. Шинжилгээний сорьцыг өрх, сумаас аймаг, аймгаас хот руу, хот хооронд зөөвөрлөхдөө Иргэний агаарын тээврийн компани, төмөр зам, автотээврийн байгууллагуудтай гэрээ байгуулж тээвэрлэж болно.
6. Агаарын тээвэр, төмөр зам болон автотээврийн компанийтай байгуулсан гэрээний үндсэн дээр шинжилгээний сорьц тээвэрлэхдээ Зам, тээврийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Биоаюултай илгээмж тээвэрлэх журам”-ыг баримтална.
7. Сорьц тээвэрлэх зардлыг илгээж буй байгууллага өөрийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулж ажиллана
8. Шинжилгээний сорьц илгээх байгууллага, шинжилгээ хийх эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажиллах гэрээ байгуулна.
9. Шинжилгээний сорьцны хуруу шил, зүү, цэр, шээсний шинжилгээний сав зэрэг эмнэлгийн хэрэгслэлийн хангалтыг 2 тал гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Шинжилгээний сорьц илгээх, зөөвөрлөхөд
тавигдах шаардлага**

1. Эмчийн бичсэн шинжилгээний заалтын дагуу хийгдэх шинжилгээг сувилагч болон лабораторийн мэргэжилтэн авна.

2. Шинжилгээний сорьцыг үйлчлүүлэгчээс аваахдаа эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлийн стандарт, халдварт хамгааллын дэглэмийг чанд баримтлана.

3. Сорьцыг шинжилгээ хийх лаборатори руу зөөвөрлөхдөө Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Гурван суурьт савлалт”-ын шаардлагыг хангасан байна.

4. Шинжилгээний сорьцыг доорхи байдлаар савлан зөөвөрлөнө. Үүнд:

- Эхний сав нь Шинжилгээний сорьцыг агуулсан, шингэн гоожихоос хамгаалсан, ус нэвтрүүлдэггүй сав байна. Сав гэмтэж доторхи шингэн асгарах тохиолдолд шингэнийг бүрэн шингээх материалыаар савыг ороосон байна.

- Хоёр дахь сав нь ус үл нэвтрэх, бат бөх, битүүмжлэгдсэн, дээж бүхий эхний савыг хамгаалах сав байна. Хоёр дахь саванд хэд хэдэн шинжилгээний эхний савыг байршуулж болно.

Эхний дээж бүхий савыг шингэн шингээх зөвлөн материалыаар тус тусад нь ороож хоёр дахь саванд хийнэ.

- Гурав дах /гаднах/ сав нь хоёрдахь савыг тээвэрлэлтийн үед гэмтэх, халах, норох, хөлдөхөөс хамгаалах зорилготой хамгийн гаднах сав юм.

5. Шинжилгээний сорьцыг дүрслэх, ялгах зорилгоор илгээмжийн тухай мэдээлэл бүхий таних тэмдгүүд болон бусад мэдээллийг гуравдугаар савны гадна наасан байна.

6. Сорьц зөөвөрлөх сав нь агуулагдах зүйлийг ямарч тохиолдолд гадагшаа алдагдахгүй байх, тээвэрлэлтийн жирийн нөхцөлд төдийгүй доргилт, температур, чийг, даралтын өөрчлөлтөөс сэргийлж чадахуйц байхаар аюулгүй байдлыг илгээгч хангасан байна.

7. Шинжилгээний сорьц авсан хуруу шил, зориулалтын саван дээр Овог нэр, нас, хүйс, шинжилгээ авсан огноог гаргацтай бичсэн байна.

8. Үйлчлүүлэгчээс шинжилгээний сорьц авсан даруйд шинжилгээнд илгээх хуудсан дээр хуруун шилэн дээр байгаа кодыг наана.

9. Шинжилгээний илгээмжийн дагалдах бичигт :

- Үйлчлүүлэгчийн овог нэр, нас, хүйс,
- Эрүүл мэндийн даатгалын хуудас
- Шинжилгээг илгээж буй байгууллагын нэр, хаяг, утасны дугаар, цахим хаяг
- Хүлээн авч буй байгууллагын нэр, хаяг, утасны дугаар
- Сорьц авсан он сар өдөр
- Сорьц авсан ажилтны нэр, утасны дугаар
- Шинжилгээний нэр, төрөл, хийгдэх үзүүлэлт бүрийг тодорхой гаргацтай бичнэ.

10. Шинжилгээ хийх лабораторит сорьц илгээхдээ Эрүүл мэндийн анхан шатны маягт АМ-21 “Шинжилгээнд илгээх бичиг” буюу шинжилгээний захиалгын хуудсын дагуу ирүүлнэ.

Гурав. Шинжилгээний сорьцыг илгээх эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1. Өрх, сум, тосгоноос аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв, эмнэлэг лавлагаа тусlamж үзүүлэх эрүүл мэндийн байгууллага руу шинжилгээний сорьц зөөвөрлөхийг тухайн эрүүл мэндийн байгууллага харилцан зөвшилцөж тээвэрлэнэ.

2. Шинжилгээний сорьцын халдвартын аюулын зэрэг, тээвэрлэлтийн онцлог (температур, хагарч гэмтэх, чийг уснаас хамгаалах)-ийг харуулсан тусгай тэмдэг (бионаоулгүйн тэмдэг) зэргийг шинжилгээ илгээгч нь ховхорч унахааргүйгээр гаднах савлаганаан дээр наасан байна.

3. Сорьцыг авах, цуглуулах, илгээх, зөөвөрлөх, хүлээн авах ажилтан, нэгжийн үүрэг, хуваарилалтыг эрүүл мэндийн байгууллагууд дотоод журмаараа зохицуулна.

4. Сорьцыг илгээгээд, шинжилгээний хариуг цахимаар хүлээж авсан эрүүл мэндийн байгууллага хариуг цаасаар хэвлэж, эмч гарын үсэг зурж баталгаажуулан үйлчлүүлэгчид өгнө.

5. Шинжилгээний сорьц авах, цуглуулах, зөөвөрлөх, тээвэрлэх талаар ажилтнуудаа сургалтанд хамруулна.

6. Шинжилгээний хариуг цахим сүлжээ, программ хангамжийн хүчин чадлаас хамааран үйлчлүүлэгчид цахим хаягаар болон кодоор өгч болно.

Дөрөв. Шинжилгээний сорьцыг хүлээж авах, шинжилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1. Шинжилгээний сорьцыг хүлээн авах эрүүл мэндийн байгууллага нь сорьц хүлээн авах ажилтан, цагийн хуваарь, журмыг батлан гаргана.

2. Шинжилгээний сорьцыг хүлээж аваадаа тээвэрлэлтийн нөхцөл, битүүмжлэл, бүрэн бүтэн байдал, дагалдах бичиг баримтын бүрдлийг шалгаж, хүлээн авсан тухай тэмдэглэл хийнэ.

3. Эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн шинжилгээний сорьцыг шинжилгээ хийх байгууллага хүлээн авсан огноо, цаг хугацаа, хүлээн авсан ажилтны нэрийг тодорхой бичин хүлээн авна.

4. Шинжилгээний сорьц асгарсан, бүрэн бүтэн байдал алдагдсан шаардлага хангахгүй тохиолдолд тэмдэглэл хийн сорьц илгээсэн эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

5. Эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн шинжилгээний сорьцыг шинжилгээ, онош тодруулах лавлагаа шинжилгээг хийнэ.

6. Шинжилгээг хүлээн авагч эрүүл мэндийн байгууллага болон лаборатори нь шинжилгээг хийж хариуг шинжилгээний сорьц ирүүлсэн эрүүл мэндийн байгууллага руу цахимаар илгээнэ.

7. Цахимаар хариу илгээсэн тухай мэдээллийг сорьц илгээгч байгууллага руу утсаар давхар мэдээлнэ.

8. Сорьц хүлээн авах, шинжилгээ хийх, цахимаар хариу илгээхдээ чирэгдэлгүй шуурхай үйлчилнэ.